

**ЕБС-ИЙН 8,9-Р АНГИЙН СУРАГЧДАД**  
**АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**  
(Сургалтын менежерт зориулсан сургалтын модуль)

С.Ариунгэрэл /БМДИ-ийн арга зүйч /

[Ariungerel@itpd.mn](mailto:Ariungerel@itpd.mn)

**СУРГАЛТЫН МОДУЛЬ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА**

Хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт, үйлдвэрлэлийн шинэчлэлийг дагаж хурдацтай хувьсан өөрчлөлт нь сургуулийн үйл ажиллагаа болон багшийн ажилд ч өөрчлөлтийг бий болгож байна. Мөн ухаалаг утас, таблет, интернэт хүүхдүүдийн өдөр тутмын хэрэглээ болж, тэд өөрийн улс орон төдийгүй дэлхийн хэмжээний мэдээлэл авах, харилцах боломжтой болсон. Үйлдвэрлэл, үйлчилгээний хурдацтай шинэчлэл, амьдралд хурдацтай нэвтэрч байгаа өндөр технологи, шинэ материалууд, нано, биотехнологи нь ажлын байранд шинэ, нэмэлт ур чадваруудыг шаардах боллоо. Иймээс хүүхэд бүрийн ялгаатай байдлыг тооцон тэдний авьяас сонирхол, хөгжлийг дэмжин, ирээдүйн зорилготой нийцүүлэн сургалтыг уян хатан байдлаар зохион байгуулах, нөгөө талаас суралцагчдын өөрийн сонирхол, чадвар, үнэт зүйлээ таньж мэдэх хувь хүний хэрэгцээнд тулгуурлан ирээдүйн ажил мэргэжилд эртнээс үр дүнтэй бэлтгэх, ирээдүйн ажил мэргэжилтэйгээ уялдуулан хичээлээ сонгон судлах боломжийг олгож улмаар ажлын байранд шаардагдах ур чадвар, өөрийн үнэлэмж, бодит байдал, ажил хайх, ажил хөдөлмөрт бэлтгэх талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх зэрэг нь сургуулийн үндсэн үүрэг юм. Сурагчид өөрсдийн тэмүүлэл, үнэ цэнийг ойлгох, нийгэмд өөрийн ач тусыг хэрхэн нэмэрлэх талаар ойлголтыг бүрдүүлэхэд нь туслах, амьдрал ажил мэргэжлийн талаар сонголтоо зөв хийхэд нь туслах, ажил мэргэжлээ төлөвлөх арга барил эзэмшүүлэх зэргээр өөрийгөө танин мэдэх, хүсэл сонирхлоо ойлгох, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах, үйл ажиллагаандаа хариуцлагатай хандах, өөрийн хариуцлагыг ухамсарлуулах, аливаа өөрчлөлтийг даван туулахад нь сургуулийн зүгээс зөв менежмент хийж удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах хэрэгцээнд үндэслэв.

**МОДУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ**

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа нь тасралтгүй явагдана. Монгол улсад 2009 оноос хойш ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлсэн. ЕБС-ийн хувьд 2016 оноос эхлэн Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дэмжих төслөөс 8-12-р ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг зохион байгуулах талаар багш, удирдах ажилтан, эцэг эх, сурагчдад чиглэсэн сургалт үйл ажиллагааг зохион байгуулснаар тодорхой үр дүнгүүд гарч эхлээд байна.

ЕБС-ийн удирдах ажилтнуудад дараах чиглэлээр зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Сурагч, эцэг эхчүүдэд ажил мэргэжлийн чиглэлээр мэдээлэл авч болох төрөл бүрийн арга хэлбэр, эх сурвалжийн талаар чиглүүлдэг байх
- Суралцагч бүрийн зан төлөв, хандлага, харилцаа, ур чадварыг судлан тохирох мэргэжлүүдийн танилцуулгыг хийж мэргэжлээ сонгоход нь тусалдаг байх
- Суралцагч бүр сонголтоо зөв хийх боломжийг олгон сонгосон мэргэжлийнхээ суурь шалгалтыг өгөхөд шаардлагатай хичээлүүдийг судлуулахад анхаарах
- Сурагч, эцэг эхчүүдэд гадаад дотоодын их дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн талаарх мэдээлэл, хаяг байршил, вэб сайт, бэлтгэдэг чиглэл, төлбөр мөнгөний талаарх мэдээллийг хамтран судлах, сонгоход нь туслах

- Хурдацтай өөрчлөгдөж буй нийгэмтэй хөл нийлүүлэн алхах чадварлаг хүний нөөцийг ЕБС-иас нь бэлтгэх, хувь хүний төлөвшил, хүсэл мөрөөдлөө олоход нь туслах чиглэлээр багш нараа чадавхжуулах
- Сургууль дээр байгаа сэтгэл зүйчийг энэ чиглэлээр ажиллуулах
- Багш, эцэг эхчүүдийг зөвлөгөө өгөх арга техникт суралцуулах
- Суралцагчдыг өөрийгөө таних, ур чадвараа тодорхойлох, зорилго алсын хараагаа тодорхойлох аргад сургах
- Хүүхэд бүрийн харилцааны ур чадварыг сайжруулах

8, 9-р ангийн сурагчдын дунд дараах чиглэлээр үйл ажиллагааг зохион байгуулах . Үүнд:

- ✓ Өөрийгөө таних сэтгэл зүйн сорил ажиллуулж хэв шинжийг тодорхойлуулах
- ✓ Мэргэжил сонголтод нөлөөлдөг сэтгэлзүйн онцлог, хэв шинжийн талаар
- ✓ Хүн-хүнтэй харьцдаг мэргэжлийн онцлог
- ✓ Хүн-амьд байгальтай харьцдаг мэргэжлийн онцлог
- ✓ Хүн-техниктэй харьцдаг мэргэжлийн онцлог
- ✓ Хүн-тэмдэгт, тэмдэгтийн системтэй харьцдаг мэргэжлийн онцлог
- ✓ Хүн-уран сайхны дүртэй харьцдаг мэргэжлийн онцлог
- ✓ Хүн- цахим технологитой харьцдаг мэргэжлийн онцлог
- ✓ Ирээдүйн хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага, тавигдах шаардлага

**8,9-р ангийн сурагчдаар ажил мэргэжлийн төлөвлөгөөг гаргуулах Жишээ нь:**

Асуулт	Хариулт
Хот\аймаг\дүүрэг\сум	
Овог нэр	
Сургууль	
Анги\бүлэг\	
Нас\хүйс	
Эцэг эх асран хамгаалагчийн эрхэлдэг ажил	
Ажлын хэсэг	
Хамгийн их сонирхож буй 2 чиглэлээ бичнэ үү?	1..... 2.....
Чиний сонирхлын чиглэлтэй уялдаатай цаашид илүү ихийг олж мэдэхийг хүсэж байгаа хөдөлмөрийн салбар 2-ыг бичнэ үү?	1..... 2.....
Сонгосон хөдөлмөрийн салбараас сонирхож буй 2 ажил мэргэжлийг бичнэ үү?	1..... 2.....
Сургуулиа төгссөний дараа элсэн суралцахыг хүсэж байгаа их дээд сургууль, коллеж, эсвэл мэргэжлийн боловсролын сургуультай холбоотой 2 хичээл судлахаа бичнэ үү?	1..... 2.....
Сургалтын хэсэг	
Чиний сонгосон мэргэжилтэй холбоотой зайлшгүй судлах 2 хичээл юу вэ?	1..... 2.....
Чиний хамгийн дуртай 2 хичээл юу вэ?	1..... 2.....
Чиний хамгийн сайн сурдаг 2 хичээл юу вэ?	1..... 2.....
Чиний хамгийн хэцүү санагддаг 2 хичээл юу вэ?	1..... 2.....
Чадварын хэсэг	
Чиний хамгийн сайн эзэмшсэн 2 чадвар юу вэ?	1.....

Энэ 2 чадвар таны сонирхож байгаа ажил мэргэжилд чухал гэж та бодож байна уу. Яагаад?	..... .....
Үнэт зүйлийн хэсэг	
Чиний хувьд хамгийн чухал гэж үзэж байгаа 2 үнэт зүйл юу вэ?	1..... 2.....
Чиний сонирхож байгаа ажил мэргэжилд энэ 2 үнэт зүйл яагаад чухал гэж та бодож байна вэ?	..... .....
Хувь хүний арга барилын хэсэг	
Сургууль болон гэртээ ямар нэг ажил хийх даалгавар гүйцэтгэхдээ чи ямар аргаар бусадтай харилцдаг, ойлголцдог, шийдвэр гаргадаг, төлөвлөдөг, зохион байгуулдаг вэ?	Харилцахдаа (Өөрөө чимээгүй хийдэг) эсвэл..... Аливаа зүйлийг ойлгохдоо (Заавар удирдамжийг дагадаг)эсвэл ..... Шийдвэр гаргахдаа (Логикт анхаарал хандуулдаг)эсвэл ..... Төлөвлөх, зохион байгуулахдаа (Урьдчилан төлөвлөдөг)эсвэл.....
Чиний сонирхож байгаа ажил мэргэжилд ямар нэг даалгавар гүйцэтгэх эсвэл үүрэг хүлээн ажиллахад дээр дурдсан шинж чанарууд яагаад хэрэгтэй гэж бодож байна вэ? түүнийгээ бичээрэй.	..... ..... ..... .....
Ажиллах арга барилын хэсэг	
Чи ямар нэг ажил гүйцэтгэхдээ ямар арга барилаар ажилладаг вэ? өөртөө байдаг 2 арга барилаа бичнэ үү?	1. Өгсөн даалгавраа ойлгож урьдчилан сайн төлөвлөдөг эсвэл..... 2. Анхаарал сайн төвлөрүүлдэг эсвэл.....
Сурлагын амжилтын хэсэг	
Хичээлүүд.....	Дүн .....
Сонголтын хэсэг	
Чи 10-р ангид орохдоо МСҮТ, лицей, урлагийн гэх мэт төрөлжсөн сургуульд орох уу, эсвэл өөр сургуульд шилжих үү?	
10-р ангид сонгон судлах хичээл	
Хичээлүүд.....	..... .....
Баталгаажуулах хэсэг	
Суралцагч	
Эцэг эх	
АУБ	
Эргэж дүгнэх хэсэг	
Заавал эргэж дүгнэнэ.	.....он.....сард
Сонгосон хичээлүүдээ амжилттай сурч байгаа эсэх	Тийм                      Үгүй
Сонгосон хичээлүүдийнхээ сурлагын амжилтыг сайжруулах шаардлагатай	Тийм                      Үгүй
Дараагийн удаа хичээл сонголтоо өөрчлөх талаар дахин бодох хэрэгтэй.	Тийм                      Үгүй
Хичээлийн нэр:	.....
Багш, эцэг эхийн санал, зөвлөмж	.....

## МОДУЛИЙН ЗОРИЛГО

ЕБС-ийн сургалтын менежер 8-9-р ангийн суралцагчдын сонирхол, чадавх болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг харгалзан ажил, мэргэжлээ сонгож, цаашид сонгосон мэргэжлээрээ сурч, ажил хөдөлмөр эрхлэх, өсөж хөгжихөд нь шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх замаар сургууль дээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэсэн сургалт, үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж ажиллахад оршино.

## МОДУЛИЙН ЗОРИЛТ

*Мэдлэг эзэмшүүлэхийн тухайд:*

- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны талаарх үзэл санаа, суурь боловсролын сургалтын хөтөлбөр, сургуулийн хөтөлбөр, хичээл, хичгээлээс гадуурх үйл ажиллагааны уялдаа холбоо, сургуулийн менежментийг сайжруулах аргачлалд суралцана.

*Чадвар эзэмшүүлэхийн тухайд:*

- 8,9-р ангийн сурагчдын ажил мэргэжлийн чиг баримжааны талаарх ойлголтын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, багш, сурагч, эцэг эхэд зөвлөн туслах чадвараа сайжруулж хичээл үйл ажиллагааг хүүхдийн хүсэл сонирхол, ялгаатай байдалд үндэслэн зохион байгуулах арга замаа тодорхойлно.

*Хандлага төлөвшүүлэхийн тухайд:*

- Суралцагчид ирээдүйн ажил мэргэжлээ сонгоход нь сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх чадварт суралцана.

## СУРГАЛТЫН АГУУЛГА

	Агуулгын хүрээ	Хүрэх үр дүн	Ашиглах материал
1	Суурь боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд ажил мэргэжлийн чиг баримжааны тухай үзэл баримтлалыг олж хэрэгжүүлж буй арга туршлагаа хуваалцана.	Суурь боловсролын сургалтын хөтөлбөр
2	Сургуульд суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөр боловсруулах	Сургуулийн болоод анги, ангийн сургуульд суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны хөтөлбөрийн бүтцийг гаргана.	Сургуулийн хөтөлбөр
3	Хичээл, хичээлээс гадуурх үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах	Танхимд явагдаж буй сургалт, үйл ажиллагааг танхимын бус үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх уялдаа холбоог боловсруулна.	Хичээлээс гадуур үйл ажиллагааны календарь
4	Сургуулийн менежментийг бэхжүүлэх	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаатай холбоотой 8,9-р ангийн сурагчдад тулгарч буй асуудлыг тодорхойлж сургуулийн менежментээ тодорхойлно.	Сургуулийн менежментийн зураглал

## СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

### СУУРЬ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ТУССАН БАЙДАЛ

#### Зорилго:

Суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд ажил мэргэжлийн чиг баримжааны тухай үзэл баримтлалыг олж хэрэгжүүлж буй арга туршлагаа хуваалцана.

#### Мэдээлэл:

Суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн нийтлэг үндэслэлд МУ-ын Боловсролын тухай хуульд “Монгол улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино” гэж, Бага, дунд боловсролын тухай хуульд “ Бага дунд боловсролын зорилго нь суралцагчдад ерөнхий боловсрол эзэмшүүлэх, эх оронч үзэл төлөвшүүлэх, хүмүүнлэг ёсонд суралцах, авьяас чадвараа хөгжүүлэх, амьдрал хөдөлмөрт болон тасралтгүй суралцахад өөрийгөө бэлтгэхэд нь туслахад оршино” гэж тус тус заажээ.

МУ-ын их хурлын 12-р тогтоолоор 2015 онд баталсан Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого-ын 3-р зүйлийн 3.4 дэх заалтад “Суурь боловсролыг амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадамж эзэмших үе хэмээн хөгжүүлнэ гэж тодорхойлсон.

“Бага дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлалд”-д нийгмийн амьдралын таатай орчин, хэм хэмжээг бий болгох, түүнд дасан зохицож амьдрах чадвартай, иргэншсэн монгол хүнийг төлөвшүүлэх, хүүхдийн сурч боловсрох хүсэл сонирхол, хийж бүтээх тэмүүллийг боловсролын түвшин бүрд дэмжиж ажиллахыг боловсролын зорилго болгон дэвшүүлсэн бөгөөд хандлага, төлөвшил, зан үйлд гарч буй өөрчлөлтөд “Сурагчийн сонирхол нь аливаа юмс үзэгдэл, тэдгээрийн хувирал, зүй тогтлыг судлах сонирхолтой болж хичээл болон үйл ажиллагаанд өөрийн хүслээр бүтээлч, санаачилгатай, үр дүнтэй оролцож байгаагаар илэрнэ. Идэвх зүтгэл нь сурах үйлээ төлөвлөж, төлөвлөснөө хэрэгжүүлэхийн төлөө үр бүтээлтэй ажиллаж буй байдлаар илэрнэ. Эрмэлзэл нь өөрийн удирдлагатай, хариуцлагатай, үнэт зүйлсийг эрхэмлэдэг, хамтран ажиллах чадвартай иргэн төлөвших хандлагыг илрүүлэхэд чиглэх ба дараах шалгуураар үнэлнэ гэж заасан нь суралцагч ирээдүйн ажил мэргэжлээ өөрийн хүсэл сонирхолдоо үндэслэн сонгоход чухал нөлөөтэй үйл ажиллагааны заалт юм.

Хүснэгт

Анги	Суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал	Ажил мэргэжлийн чиг баримжааны талаар сурагчийн сонирхол, сонголтын талаарх өнөөгийн байдал	Цаашид боловсронгуй болгох сургуулийн үзэл баримтлал
8-р анги			
9-р анги			

## СУРГУУЛЬД СУУРИЛСАН АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ НЬ

### Зорилго:

Сургуульд суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн 8, 9-р ангийн хөтөлбөр боловсруулах

### Мэдээлэл:

Ажил мэргэжлийн чиг баримжааг сургуулийн онцлогт нийцүүлэн сургуульд суурилсан байдлаар төлөвлөх нь зүйтэй.

Сургуулийн онцлогийг эргэж харж, дүгнэхийн тулд газарзүйн байршил, орон нутгийн эдийн засгийн төлөв, эцэг эхийн сонирхол, сургуулийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, багш нарын сонирхол, чадамж, суралцагчдын гэр бүлийн нийгэм, эдийн засгийн нөхцөл, ойр орших их, дээд сургууль эсвэл мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, интернет холболтын чанар, хурд, сургуулийн уламжлал, орон нутгийн нөөц бололцоо, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал зэргийг анхааралтай судлах шаардлагатай.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөр ч гэсэн сургууль бүрт өөр өөр байна. Учир нь энэ хөтөлбөрийг хийхэд сургуулийн онцлог шинж чанар заавал тусгагдсан байх хэрэгтэй юм.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөрийг сургуулийн удирдлага эцэг эх, суралцагчидтай хамтран боловсруулна. Ингэхдээ сургуулийн онцлог, суралцагчийн хэрэгцээ, сургуулийн дотоод болон гадаад нөөц бололцоог харгалзан үзнэ. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөрийн төлөвлөлт нь сургуулийн түвшинд энэ үйл ажиллагааг бодитой хэрэгжүүлэх схемийг бий болгох үйл явц юм. Энэ хөтөлбөр нь тодорхой бүрэлдэхүүн, үе шаттай байна.

### Сургуульд суурилсан хөтөлбөрийн төлөвлөлт

Хөтөлбөрийн бүрэлдэхүүн	Агуулга
1. Үндэслэл	Яагаад тухайн сургууль ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх шалтгаан
2. Зорилтот бүлэг	8-12-р ангийн суралцагч
3. Зорилго	Сургуулийн түвшний мөн анги ангийн зорилго байж болно.
4. Зорилт	Зорилт нь зорилгод хэрхэн хүрэхийг тодорхойлно. Ажил мэргэжлийн уялдаа холбооны талаарх ойлголтыг сайжруулах, суралцагчийн ирээдүйн төлөвлөлт хийх чадамжийг сайжруулах гэх мэт зорилгын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлсэн, тодорхой байна.
5. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Сургуулийн орчинд хэрэгжүүлэх үйл ажиллагаа Сургуулиас гадуурх үйл ажиллагаа
6. Нөөц	Сургуулийн дотоод нөөц: багш, нийгмийн ажилтан, компьютерийн лаборатори, номын сан, интернет холболт, ном, гарын авлага, суралцагч, эцэг эх Сургуулийн гадаад нөөц:
7. Үйл ажиллагааг хэрэгжүүлж дуусах хугацаа	Хичээлийн жилийн амралтыг харгалзан үйл ажиллагаа тус бүрийг хэрэгжүүлж дуусах хугацааг тодорхойлсон байна.
8. Үнэлгээ	Явцын үнэлгээ их олон янзын арга байна: хичээлийн жилийн төгсгөлд суралцагчдаас, эцэг эхийн асуулга судалгаа авч болно, багш нар өөрийн үнэлгээ хийж болно. Үнэлгээг хамгийн гол нь хөтөлбөрт дэвшүүлсэн зорилго, зорилттой уялдуулж хийнэ.

## Ангид суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөрийн төлөвлөлт

Хөтөлбөрийн бүрэлдэхүүн	Агуулга
1. Үндэслэл	Яагаад ажил мэргэжлийн чиг баримжааг хэрэгжүүлэх шалтгаан
2. Зорилтот бүлэг	Тухайн ангийн бүх суралцагчид
3. Зорилго	Ангийн түвшний зорилго ерөнхий байж болно.
4. Зорилт	Зорилт нь зорилгод хэрхэн хүрэхийг тодорхойлно. Жишээ нь хувь хүний болон практикийн чадвар, ур чадвараа удирдан чиглүүлэх, их, дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтийн байгууллагын брошурыг ойлгох, үнэлэх, сургууль төгссөний дараах ажил мэргэжлийн сонголтоо ухаалгаар хийх, сонгосон ажил мэргэжилтэй уялдаатай, хөрвөх боломжтой ажил мэргэжлийн олон янзын боломжийг эрэлхийлэх чадамжийг сайжруулах гэх мэт зорилгын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилттой байж болно.
5. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Сургуулийн орчинд хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Сургуулиас гадуурх үйл ажиллагаа:
6. Нөөц	Сургуулийн дотоод нөөц: багш, нийгмийн ажилтан, компьютерийн лаборатори, номын сан, интернет холболт, ном, гарын авлага, суралцагч, эцэг эх
7. Үйл ажиллагааг хэрэгжүүлж дуусах хугацаа	Хичээлийн жилийн амралтыг харгалзан үйл ажиллагаа тус бүрийг хэрэгжүүлж дуусах хугацааг тодорхойлсон байна.
8. Үнэлгээ	Явцын үнэлгээ их олон янзын арга байна: хичээлийн жилийн төгсгөлд суралцагчдаас, эцэг эхийн асуулга судалгаа авч болно, багш нар өөрийн үнэлгээ хийж болно. Үнэлгээг хамгийн гол нь хөтөлбөрт дэвшүүлсэн зорилго, зорилттой уялдуулж хийнэ.

Сурагчдын сонирхлыг тодорхойлох нь хүүхэд хийж байгаа зүйлдээ дуртай, сэтгэл хангалуун байх нь ажилдаа амжилт гаргах, сэтгэл хангалуун байхын үндэс. Хэрэв та хаашаа явахыг хүсэж байгаагаа мэдэхгүй бол аль зүгт явах вэ гэдэг нь тийм ч чухал биш. Үүнтэй адил тодорхой чиглэл байхгүй бол та нэг ажлаас нөгөө ажилд бөмбөг шиг л ойж буусаар байх болно. Аль ч ажилдаа сэтгэл хангалуун байж чадахгүй. Зарим хүмүүс эрхэлдэг ажил хөдөлмөртөө дургүй байдаг нь тэд хэзээ ч ажил мэргэжлийн сонголтод ач холбогдол өгч байгаагүйг илтгэдэг. Тэд ажил мэргэжлээ сонгохдоо зүгээр л биед амар, цалин ихтэй болохоор эсвэл найзыгаа, ахыгаа, эгчийгээ, ээж аавыгаа дууриагаад, эсвэл хэн нэг нь тухайн ажлыг өөрт тохирно гэж хэлсэн учраас л сонгосон байдаг. Эсвэл элсэлтийн шалгалтад амжилт үзүүлж чадах учраас сонгосон байдаг. Үр дүнд нь тэд ажилдаа дургүй, сэтгэл ханамжгүй нэгэн болдог. Ийм хүмүүсийн ихэнх нь өөртөө цаг гаргаад юу хүсдэг, сонирхдог болохоо эргэцүүлээгүй байдаг. Магадгүй тэдэнд ийм боломж ч байгаагүй байх. Хийх дуртай зүйлээ таньж мэднэ гэдэг нь өөрийгөө таньж мэдэхийн эхлэл юм. Зарим хүмүүс амьдралын нугачаан дунд юу хүсдэг, сонирхдог болохоо санахгүй эсвэл огт мэдэхгүй болсон байж болно. Гэхдээ хүн бүрт хүсдэг, сонирхдог, хийх дуртай зүйл гэж байдаг. Ямар ч ажил хийдэг байлаа хүн хийж байгаа зүйлдээ дуртай л бол ажил мэргэжилдээ сэтгэл хангалуун байдаг. Ажил, амьдралын АМЖИЛТ тухайн хүний ДАВУУ ТАЛААС шалтгаалдаг. Сонирхлоо тодорхойлох, ур чадвараа нээж илрүүлэх гэдэг нь давуу талаа таньж мэдэж байгаа хэрэг. Таны сонирхол, ур чадвар 2 нийцтэй байвал энэ таны жихэнэ ДАВУУ ТАЛ болно.

**ХИЧЭЭЛ, ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛАХ**

Зорилго: Танхимд явагдаж буй сургалт, үйл ажиллагааг танхимын бус үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх уялдаа холбоог боловсруулна.

Сургууль бол ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхимын үйл ажиллагааг зохион байгуулах хамгийн тохиромжтой газар. Учир нь суралцагчдыг бүлгээр зохион байгуулж ажил мэргэжлийн чиг баримжааг илүү системтэй, зохион байгуулалттай хэрэгжүүлэх боломжтой юм. Түүнчлэн энд л хүүхдүүд бие биенээсээ суралцах боломжтой байдаг.

Ерөнхий боловсролын сургуулиуд ажил мэргэжлийн тодорхой туршлагатай, мэдээлэлтэй эсвэл мэдлэгтэй хүмүүсийг (эцэг эх, тухайн сургуулийн төгсөгчид, ажил олгогч, мэргэжлийн холбоод, сургалтын байгууллага, орон нутгийн хөдөлмөрийн хэлтэс гэх мэт) сургуульдаа урьж, суралцагчидтай ажил мэргэжлийн талаар ярилцаж, илтгэл тавьж, хэлэлцүүлэг хийх үйл ажиллагааг зохион байгуулж болно. Суралцагчид танхимын болон танхимын бус үйл ажиллагааны хүрээнд мини-компани эсвэл аж ахуйн нэгжийг байгуулж болно. Орон нутгийн нэр хүнд бүхий аж ахуй эрхлэгчид, бизнесүүдийг урьж, суралцагчдын мини-компани, аж ахуйн үйл ажиллагаанд зөвлөгөө өгч болно.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг сургуулиас гадуур мөн зохион байгуулж болно. Ажлын туршлага хуримтлуулах, ажлын байранд зочлох, боловсролын яармагт очих, хөдөлмөр эрхлэлтийн яармагт зочлох гэх мэт үйл ажиллагааг нэрлэж болно.

**Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэдлэг, чадвар, холбогдох үйл ажиллагаа**

МЭДЛЭГ, ЧАДВАР	СУРГУУЛИЙН ОРЧИНД	СУРГУУЛИАС ГАДУУР
1. Өөрийн чадвар болон ажил мэргэжлийн сонирхлын талаарх мэдлэг	<ul style="list-style-type: none"> <li>i) Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхимын үйл ажиллагаа ангийн багш болон нийгмийн ажилтан хамтран “Суралцагчийн гарын авлага” ашиглан зохион байгуулах</li> <li>ii) Сурлагын амжилт</li> <li>iii) Сургуулийн клуб олон сургалтыг дэмжих үйл ажиллагааны оролцох</li> <li>iv) Нийгмийн ажилтан ажил мэргэжлийн чиглэлээр ганцаарчилсан зөвлөгөө өгөх</li> <li>v) Ажил мэргэжлийн сорил</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Цагийн ажил</li> <li>✓ Сайн дурын үйл ажиллагаа</li> <li>✓ Ажлын туршлага хуримтлуулах үйл ажиллагаа</li> <li>✓ Гэр бүлийн үүрэг, оролцоо</li> <li>✓ Найз нөхдийн үүрэг, оролцоо</li> <li>✓ Чөлөөт цагаараа хийх үйл ажиллагаа</li> <li>✓ Хөгжим, спорт, бүжиг, урлагийн дугуйлан, секц</li> </ul>
2. Ажил мэргэжил, ажлын ертөнц, ажилд тавигддаг хувь хүний болон мэргэжлийн шаардлага, ажил мэргэжил эзэмших олон янзын сургалтын замнал болон ажил хайх тухай мэдлэг	<ul style="list-style-type: none"> <li>i) Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхимын үйл ажиллагаа ангийн багш болон нийгмийн ажилтан хамтран “Суралцагчийн гарын авлага” ашиглан зохион байгуулах</li> <li>ii) Ажил мэргэжилтэй холбоотой ном гарын авлага</li> <li>iii) Ажил мэргэжилтэй холбоотой вэбсайт</li> <li>iv) Эцэг эх, төгсөгч, ажил олгогч, Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн, мэргэжлийн холбоодын төлөөлөл илтгэл тавих, ярилцлага хийх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Ажлын туршлага хуримтлуулах</li> <li>✓ Цагийн ажил</li> <li>✓ Гэр бүлийн үүрэг</li> <li>✓ Орон нутгийн эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтэд хувь нэмэр оруулах</li> <li>✓ Ажлын байранд зочлох</li> <li>✓ Ажил мэргэжлийн яармаг, үзэсгэлэн</li> <li>✓ Хэвлэл мэдээллийн хэрэгсэл</li> <li>✓ Вэбсайт</li> </ul>



	v) Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын “Ажил олгогчдын шаардлага”-ын судалгаа	
3. Төрийн болон хувийн их, дээд сургууль, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, сургууль, өдрийн, эчнээ, оройн, зайн болон ЦОС сургалтын төрлийн талаарх мэдээлэл. Энэ мэдээлэл нь хөтөлбөрийн зорилго, зорилт, тухайн хөтөлбөрөөр эзэмшүүлэх мэргэжил, сургалтын хугацаа, зардал болон хөтөлбөрөө дүүргээд ажил хөдөлмөр эрхлэх боломжийн талаар агуулгатай байна.	<p>i) Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхимын үйл ажиллагаа ангийн багш болон нийгмийн ажилтан хамтран “Суралцагчийн гарын авлага” ашиглан зохион байгуулах</p> <p>ii) Ажил мэргэжилтэй холбоотой ном, гарын авлага</p> <p>iii) Мэргэжлийн боловсрол, сургалт, их, дээд сургууль, зайны болон цахим сургалтын тухай вэбсайтууд (<a href="http://www.mergejil.mn">www.mergejil.mn</a>, <a href="http://www.num.edu.mn">www.num.edu.mn</a>, <a href="http://www.msue.edu.mn">www.msue.edu.mn</a> гэх мэт)</p> <p>iv) Төгсөгч, их дээд сургуулийн оюутан, эцэг эх, сургалтын байгууллагын төлөөлөл илтгэл тавих, ярилцлага хийх (мэргэжлийн боловсрол, сургалт, их, дээд сургууль, зайны болон цахим сургалтын)</p> <p>v) Мэргэжлийн боловсрол, сургалт, их, дээд сургууль, зайны болон цахим сургалтын элсэлтийн шаардлагын тухай мэдээлэл бүхий гарын авлага, брошур</p> <p>vi) Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн судалгааны институтын “Хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага”-ын судалгаа</p>	<p>✓ Вэбсайтаас шаардлагатай мэдээлэл цуглуулах</p> <p>✓ Сургалтын байгууллагуудын элсэлтийн талаарх мэдээлэл, гарын авлага, брошур</p> <p>✓ Сургалтын байгууллагуудад зочлох</p> <p>✓ Боловсролын яармаг, үзэсгэлэн</p> <p>✓ Хэвлэл мэдээллийн хэрэгсэл</p>
4. Ажил мэргэжлийн төлөвлөлт хийхтэй холбоотой мэдээллийг хаанаас яаж цуглуулах болон мэдээллийн эх сурвалжийг үнэлэх	<p>i) Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхимын үйл ажиллагаа ангийн багш болон нийгмийн ажилтан хамтран “Суралцагчийн гарын авлага” ашиглан зохион байгуулах</p> <p>ii) Орон нутгийн Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн уулзалт, ярилцлага хийх, зөвлөгөө өгөх</p>	<p>✓ Гэр бүл найз нөхөдтэйгээ зөвлөлдөх,</p> <p>✓ Хөдөлмөрийн хэлтсийн холбогдох мэргэжилтнээс зөвлөгөө авах</p>
5. Ажил мэргэжил, сургалтын талаарх хөндлөнгийн мэдээлэл болон өөрийн чадвар, сонирхлын талаарх мэдээллийг ашиглан төлөвлөлтийг хэд хэдэн хувилбартай хийх	Сургуулийн нийгмийн ажилтан болон анги удирдсан багш хамтран тодорхой зохион байгуулалттай үйл ажиллагааг “Суралцагчийн гарын авлага” ашиглан зохион байгуулах	<p>✓ Гэр бүл найз нөхөдтэйгээ зөвлөлдөх,</p> <p>✓ Хөдөлмөрийн хэлтсийн холбогдох мэргэжилтнээс зөвлөгөө авах</p>

**СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ**

Зорилго: Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаатай холбоотой 8,9-р ангийн сурагчдад тулгарч буй асуудлыг тодорхойлж сургуулийн менежментээ тодорхойлно.

Мэдээлэл: Сургуулийн ерөнхий дүр төрхийг буулгасан нэгдсэн зураглал боловсруулснаар тухайн жилийн сургуулийн зорилго, сургалтын үйл ажиллагааны уялдаа холбоо тодорхой болно. Ямар суралцагчийг бэлтгэхийн тулд ямар зорилго тавьж, түүндээ хэрхэн хүрэх вэ гэдгийг энэхүү загвараар тодорхой харуулна. Ингэснээр нийт багш, эцэг эхчүүд тухайн сургууль энэ жил ямар зорилгод хүрэхээр юу хийх гэж байгааг тодорхой мэдэж сургалтын үйл ажиллагаагаа оновчтой явуулах боломжтой болно.

Сургуулийн менежментийн загварт дэвшүүлсэн сургуулийн зорилго, зорилтод хүрэх үйл ажиллагааг илүү тодорхой болгон нарийвчилсан сургалтын үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө /сургалтын жилийн төлөвлөгөөг/ боловсруулж, тэр төлөвлөгөөг илүү тодорхой болгон нэгж хичээлийн хөтөлбөрийг боловсруулдаг, нэгж хичээлийн хөтөлбөрийн дагуу ээлжит хичээлийн төлөвлөгөөг боловсруулж хичээл заана. Энэхүү хоорондоо уялдаатай төлөвлөлтүүд нь нэгдсэн зорилго ба өдөр тутмын үйл ажиллагааг нэгтгэх боломжтой болж үр ашигтай, үр дүнтэй, чанартай боловсрол олгох нөхцөл нь болно.

1. Сурагчдын асуудал, хөгжүүлэх шаардлагатай чиглэлийг илрүүлэх
2. Сургуулийн зорилго, тэргүүлэх зорилтуудаа тодорхойлох

Сурагчдын хувьд хөгжүүлэх шаардлагатай чиглэлд төвлөрөн тэргүүлэх зорилтуудыг томъёолох нь чухал. Сургуулийн зорилго нь энэ хичээлийн жилд сургууль сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан юу хийх, ямар үр дүнд хүрэхийг харуулна. Зөвхөн сургуулийн менежментийн асуудлууд бичигдсэн байвал сургуулийн хувьд хамгийн чухал бүрэлдэхүүн болох хүүхэд орхигдоно. Сургууль бол хүүхдэд боловсрол олгох зорилготой тул энэ чиглэлээр юу хийхээ олон зүйлийг харгалзан сайтар тунгаасны эцэст тодорхойлно. Сургуулийн зорилгоо тодорхойлоод орхивол учир дутагдалтай. Сургуулийн багш, хамт олон “Өөрийн сургуулийн зорилгыг мэдэхгүй” бол зорилго тодорхойлоогүйтэй адил. Мөн “Зорилгоо мэдэж байгаа ч өөрөө уг зорилгыг биелүүлэхийн тулд юу хийхээ мэдэхгүй” байвал мөн л учир дутагдалтай. “Сургуульд ажиллаж буй нийт багш, хамт олон сургуулийн зорилгоо сайтар ойлгож, дор бүрнээ юу хийхээ сайн мэдэж байх” нь сургуулийн менежмент үр дүнтэй хэрэгжих нөхцөл нь болдог.

3. Сургуулийн удирдлага зохион байгуулалтыг хялбаршуулан харуулсан зураглал гэж хэлж болно. Харин энэ үе шат бол тэрхүү зураглалыг бодит амьдрал дээр хичээлтэй уялдуулах үйл ажиллагаа юм. Нэгж хичээл, ээлжит хичээлийн зорилтод хүрэх үр дүн, хүүхэд хөгжүүлэх зорилтоо тусгана. Ээлжит хичээлийн зорилт ба дидактик алхмуудыг хүрэх үр дүн, хөгжүүлэх зорилтод дэмжлэг үзүүлэх байдлаар эрэмбэлэн тодорхойлно. Хичээлийг төлөвлөхдөө зорилгоо тодорхойлохоос эхэлнэ. Ингэхдээ боловсролын болон орон нутаг, сургуулийн хувьд, сурагчдад төлөвшүүлэх, хөгжүүлэхийг зорьж буй чадвар, сурагчдын өмнөх мэдлэг, төсөөлөл, сонирхол хэрэгцээнд үндэслэн мэдлэг бүтээх үйл ажиллагааг дэмжих, хандлага төлөвшилд хувь нэмэр оруулахаар тооцно.

Хүснэгт

Асуудал		
Зорилго		
Зорилт		
Үйл ажиллагаа		

## СУРГАЛТЫН ОРЧИН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

- [www.mergejil.mn](http://www.mergejil.mn)
- [http //hudulmur-halamj.gov.mn/occ](http://hudulmur-halamj.gov.mn/occ)
- [http //jobclass.ubstat.mn/occ](http://jobclass.ubstat.mn/occ)
- [www.onisep.fr](http://www.onisep.fr)
- [www.myworldofwork.co.uk](http://www.myworldofwork.co.uk)
- [www.careers.govt.nz](http://www.careers.govt.nz)
- <https://myfuture.edu.au>
- <https://www.onetonline.org>
- .....

“Хөгжлөөс хэн ч хоцрох ёсгүй” тогтвортой хөгжлийн уриан дор ЕБС-ийн 8-12 дугаар ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг 2016 оноос эхлэн явуулж байгаа бөгөөд тогтвортой хөгжлийн боловсролын 4-р зорилт болох “Чанартай боловсрол”-ыг дэмжих үүднээс энэхүү үйл ажиллагааг улам чанаржуулах, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ЕБС-ийн удирдлага, багш, сурагч, эцэг эхчүүдэд зориулсан онлайн орчин бүрдүүлж, цахим сургалтын модуль боловсруулсан.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт үйл ажиллагаа нь сурагч өөрийгөө таньж мэдэх, үнэт зүйлээ хамгаалах, ажил мэргэжлээ зөв сонгох, хөдөлмөрийг үнэлж сурахад нь дэмжлэг үзүүлэх, ерөнхий боловсролын тогтолцоонд үр дүнтэйгээр нэвтрүүлэх, багш, сурагч, эцэг эх, сургуулийн удирдлагын мэдлэг, чадвар, хандлагыг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Иймээс нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендерийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх, жендерийн мэдрэмжтэйгээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Түүнчлэн мэргэжил сонголтод жендерийн талаарх хэвшмэл хандлагаас сэргийлэн хичээл, үйл ажиллагааг мэдрэмжтэй удирдан зохион байгуулж охид, хөвгүүдийн боломж ижил тэнцүү байдаг талаас нь ойлгуулна.

Түгээмэл биш ажил мэргэжлийн талаар ярилцахдаа илүү мэдрэмжтэй байж охид, хөвгүүдийн тэгш оролцоог хангаж ажиллах, суралцагчдад аль болох олон төрлийн ажил мэргэжлийн талаар ойлгож мэдэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллана.

